

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ, ХӨЛБӨӨНЫ ТЕХНОЛОГИЙН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Л.БАЯР-ЭРДЭНЭ
2026 оны 04 дүгээр сарын 09

КОМПЬЮТЕРЫН СҮЛЖЭЭНИЙ УЛСЫН XIV ОЛИМПИАД, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2026 оны 04 дүгээр сарын 09

Улаанбаатар хот

ЗОРИЛГО:

Компьютерын сүлжээ, кибер аюулгүй байдлын салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, мэргэжлийг сурталчлах, судлаач, инженер, оюутнуудын бүтээлч чадварыг нийгэмд таниулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжихэд оршино.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү удирдамжаар компьютерын сүлжээний улсын XIV олимпиад, эрдэм шинжилгээний хурлыг их, дээд сургуулийн оюутнууд болон залуу судлаачдын дунд нээлттэй зохион байгуулна.
- 1.2. Олимпиад нь оюутан болон инженер гэсэн хоёр ангилалд зохион байгуулагдана. Оролцогчид нь I шатанд цахимаар бүртгүүлэхдээ оролцох ангиллаа сонгож, холбогдох бүртгэлийн материалаар олимпиадын ангиллаа баталгаажуулна.
- 1.3. Тус арга хэмжээ нь олимпиад болон эрдэм шинжилгээний хурал гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд дараах хуваарийн дагуу явагдана.
 - **Олимпиадын I шат** (танхим) – 2026 оны 05 дүгээр сарын 2-ны өдөр
 - **Олимпиадын II шат** (танхим) – 2026 оны 05 дугаар сарын 09-ний өдөр (Оюутан ангилалд – 20 оролцогч, Инженер ангилалд – 10 оролцогч)
 - **Эрдэм шинжилгээний хурал** (танхим) – 2026 оны 05 дугаар сарын 09-ний өдөр
- 1.4. Олимпиадын нэгдүгээр шатанд нэг сургуулиас оролцох оюутны тоог хязгаарлахгүй бөгөөд бүртгэлийг нээлттэй хэлбэрээр явуулна.
- 1.5. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлд нэг судлаач нэгээс илүүгүй илтгэлээр оролцох боломжтой.
- 1.6. Арга хэмжээтэй холбоотой мэдээллийг дараах хаягаар ажлын цагаар лавлагаа авах боломжтой:
 - Утас: 99062394 (Кибер аюулгүй байдлын тэнхимийн багш Х.Уянгаа), 99990399 (Кибер аюулгүй байдлын тэнхимийн сургалтын мастер Д.Эрдэнэтуяа)
 - Цахим шуудан: uyangaakh@must.edu.mn

Хоёр. Зохион байгуулалт

2.1. Олимпиад, эрдэм шинжилгээний хурлыг ШУТИС-ийн Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн (МХТС) Кибер аюулгүй байдлын тэнхим болон хамтран ажиллагч, ивээн тэтгэгч байгууллагууд хамтран зохион байгуулна. Арга хэмжээний мэдээ, мэдээллийг <https://www.sict.edu.mn> сайтад байршуулна.

2.2. Олимпиадын I шатанд оролцогч 2026 оны 04 дүгээр сарын 16-наас 04 дүгээр сарын 30-ны хооронд <https://olympiad.sict.edu.mn> сайтаар онлайн бүртгүүлнэ. Оролцогч нь дараах материалуудыг онлайн бүртгэлийн маягтад файлаар (.pdf) хавсаргана. Үүнд:

1. Иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл E-Mongolia лавлагаа
2. Оюутны үнэмлэх болон сургуулийн тодорхойлолт
3. Оюутны дүнгийн жагсаалтыг хичээлийн жил / улирлаар гаргасан хувилбар
4. Инженер ангиллын оролцогч нь ажлын газрын тодорхойлолт болон E-Mongolia дипломын лавлагаа

Бүртгэлийн материал дутуу, бүрэн бус мэдээлэлтэй оролцогчийн эрхийг баталгаажуулж мандат олгох боломжгүй.

2.3. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн файлуудыг 2026 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн дотор sict-conference@must.edu.mn хаягаар илгээнэ. Эрдэм шинжилгээний файлууд нь 250-300 үгтэй хураангуй болон илтгэлийн презентаци (.pptx) байх бөгөөд судалгааны зорилго, аргачлал, үр дүн, дүгнэлтийг товч тусгасан байна.

2.4. Оюутан ангилалд оролцогч нь мэргэжил харгалзахгүй, 1-4 дүгээр курсийн оюутан байна. Харин одоогоор суралцдаггүй, чөлөөтэй, эсхүл дөрвөн жилээс дээш хугацаанд суралцаж байгаа тохиолдолд оюутан ангилалд оролцох боломжгүй. Инженер ангилалд их, дээд сургуулийг төгссөн, эсхүл салбартаа ажиллаж буй мэргэжилтэн оролцох боломжтой.

2.5. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлд их, дээд сургуулийн бакалаврын ангиллын оюутан оролцох боломжтой.

2.6. Арга хэмжээ нь бүртгэлийн хураамжгүй байна.

2.7. Олимпиадын I шатны эхлэх цаг, холбогдох мэдээллийг <https://www.sict.edu.mn> хаягаар мэдэгдэнэ.

2.8. Олимпиадын I шатны дүнг автоматаар дүгнэж, онлайнаар мэдээлнэ.

2.9. Олимпиадын II шатанд шалгарсан оюутнууд 2026 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ШУТИС-МХТС-ийн байранд (байр, өрөөний дугаарыг веб хуудсаар мэдэгдэх болно) биеэр бүртгүүлж, эрхээ дахин баталгаажуулна.

2.10. Олимпиадын II шатанд нийт 30 оролцогч оролцох бөгөөд үүнээс 20 нь оюутан ангилалд, 10 нь инженер ангилалд байна. Оролцогчдыг I шатны дүнгээр тус тус шалгаруулна.

2.11. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд 05 дугаар сарын 09-ний өдөр ШУТИС-МХТС-ийн байранд зохион байгуулагдана. Илтгэлийн хуваарийг бүртгүүлсэн цахим шуудангаар мэдэгдэнэ.

Гурав. Шалгаруулалт, шагнал, урамшуулал

Олимпиадын шагнал:

3.1. Олимпиадын I шатны дүнгээр шилдэг үзүүлэлттэй 30 оролцогчид зохион байгуулах комиссоос II шатанд оролцох урилгыг бүртгүүлсэн цахим шуудангаар илгээнэ.

3.2. Олимпиадын II шатнаас оюутны ангилал болон инженер ангилал тус бүрээр 3 байр (I, II, III байр) шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Эрдэм шинжилгээний хурлын шагнал:

3.3. Эрдэм шинжилгээний хурлаас шилдэг илтгэлээр нийт 3 байр (I, II, III байр) шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

3.4. Шилдэг илтгэлүүдийг их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний зөвлөлийн багш, судлаач, аж үйлдвэрийн төлөөлөгчдөөс бүрдсэн комиссоор шалгаруулна.

Дөрөв. Олимпиадын даалгаврын хамрах хүрээ

- OSI, TCP/IP загвар, TCP/IP протоколын бүлгийн түгээмэл протоколууд, нээлттэй стандартууд
- Сүлжээний үндсэн тоног төхөөрөмжүүд (замчлагч, свич, галт хана, утасгүй сүлжээний төхөөрөмж г.м)-ийн технологиуд
- Компьютерын сүлжээний найдвартай ажиллагааг хангах технологиуд
- Сүлжээний хяналт, удирдлагын нээлттэй стандарт, протоколууд
- Түгээмэл хэрэглээний давхаргын үйлчилгээнүүд, серверийн зохион байгуулалт, холбогдох troubleshooting командууд
- Сүлжээний аюулгүй байдал, криптографийн үндсэн ойлголтууд, хэрэглээ
- Packet Tracer 8.2.0 ба EVE-NG 6.2.0-4- Community түүнээс дээш хувилбарт ажиллах төхөөрөмж, протоколын практик даалгаврууд

Тав. Эрдэм шинжилгээний хурлын чиглэл

Хуралд дараах сэдэвчилсэн чиглэлээр илтгэл хүлээн авна:

- Компьютерын сүлжээ, кибер аюулгүй байдал
- Сүлжээний удирдлага, хяналтын систем
- Криптограф, нууцлалын технологи
- Кибер довтолгоо илрүүлэх, сэргийлэх аргачлал
- Мэдээллийн аюулгүй байдлын засаглал, хууль эрхзүй, ба менежмент
- Сүлжээний дэд бүтэц, үүлэн технологийн аюулгүй байдал
- Компьютерын сүлжээний боловсрол, сургалтын арга зүй

Арга хэмжээг зохион байгуулагч:

ШУТИС, Мэдээлэл, холбооны технологийн сургууль
Кибер аюулгүй байдлын тэнхим